

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

Инновэйшн Инвестмент ХК нь хувьцаагаа олон нийтэд санал болгож 2023/12/04-ний өдрөөс 2023/12/08-ны өдрийн хооронд Монголын хөрөнгийн бирж дээр анхдагч зах зээлийн захиалга авч 8.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Инновэйшн Инвестмент ХК-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Эзлэх хувь	Татан төвлөрүүлсэн мөнгөн дүн	Зарцуулсан дүн
1	Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	22.5%	1,871,991,911	139,938,166
2	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа	30.0%	2,495,989,215	0
3	Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа	15.0%	1,247,994,608	1,061,274,656
4	“ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	25.0%	2,080,003,050	2,080,003,050
5	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	7.5%	623,985,266	0
	НИЙТ	100.0%	8,319,964,050	3,281,215,872

2023 оны 12 дугаар сард нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25% буюу “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох 2,080,003,050 төгрөгийг зориулалтын дагуу ККТТ ХХК руу шилжүүлсэн.

2024 онд төлөвлөж байсны дагуу QРау төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд Суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах болон одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр 1,061,274,656 төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалт хийсэн бөгөөд үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15% буюу “Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа”-нд зориулагдах 1,247,994,608 төгрөгөөс зарцуулсан.

Мөн 2024 оны 2 дугаар хагас жилээс эхлүүлсэн QРау үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой компани ажлын хүрээнд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 139,938,166 төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн “Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үйл ажиллагааны тэлэлт” хэсгээс зориулалтын дагуу зарцуулаад байна.

Бид одоогоор нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 39.4%-ийг зориулалтын дагуу зарцуулаад байгаа ба үлдсэн хөрөнгийг зориулалтын дагуу 2025 болон 2026 онуудад зарцуулахаар төлөвлөж байна.